



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/580

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.6, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, Төсвийн тухай хуулийн 41.2.2, Засгийн газрын 2018 оны “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 23 дугаар тогтоол, 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орлогыг ашиглах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Цэргийн штабын сургалтын материаллаг баазыг бүрдүүлэх, Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэглэлээр хангах зардалд 15,000,00 (арван таван сая) төгрөгийг зарцуулж, хавсралтаар баталсугай.
2. Дээрх зардлыг Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлбөрийн орон нутагт үлдэх орлогоос гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101062

Аймгийн Засаг даргын 2019 оны 09
дугаар сарын 18-ны өдрийн 1158 дугаар
захирамжийн хавсралт

**ЦЭРГИЙН ДҮЙЦҮҮЛЭХ АЛБЫГ МӨНГӨН ТӨЛБӨРИЙН ХЭЛБЭРЭЭР
ОРЛУУЛАН ХААХ ИРГЭНИЙ ТӨЛБӨРИЙН ОРОН НУТАГТ ҮЛДЭХ
ОРЛОГООС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

| № | Хийгдэх арга хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ (төг) | Нийт дүн (төг) | Тайлбар |
|---|--|------------|-------------------|----------------|---------|
| Нэг. Цэргийн штабын сургалтын материаллаг баазыг бүрдүүлэх | | | | | |
| 1 | Цэргийн штабын хичээлийн танхимын ширээ | 20ш | 80,000 | 1,600 000 | |
| 2 | Хичээлийн танхимын сандал | 40ш | 65,000 | 2,600 000 | |
| 3 | Хичээлийн танхимын засвар, тохижилт (дүүжин тааз, паракетен шал) | 80м2 | 25,000 | 2,000 000 | |
| Хоёр. Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хааж байгаа иргэнийг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хувцас хэрэглэлээр хангах | | | | | |
| 4 | Сургалтанд ашиглах майхан (30-40 хүний багтаамжтай 5.5x5.5) | 2 ком | 1,175,000 | 2,350 000 | |
| 5 | Сургалтанд хэрэглэх хээрийн халуун тогоо /60, 30, 12литр/ | 3 ш | 150,000 | 450,000 | |
| 6 | Хээрийн эрэн хувцасаар хангах (китель, өмд, малгай) | 40 хос | 100,000 | 4,000 000 | |
| 7 | Хээрийн аранз (үүргэвч)-аар хангах | 40ш | 50,000 | 2,000 000 | |
| Нийт дүн | | | 15,000 000 | | |